# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 13 өдөр Дугаар А/28.

Улаанбаатар хот

**Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төслийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 4,228,862,161.20 (дөрвөн тэрбум хоёр зуун хорин найман сая найман зуун жаран хоёр мянга нэг зуун жаран нэгэн төгрөг хорин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын балансд шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл (О.Мөнхнасан)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ (Ш.Мөнх-Оргил)-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

2024

1425039003

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 01. дугаар сарын 13. . -ны өдрийн А/28 дугаар тушаалын хавсралт

## Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл

| № | Эд хогшлын нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Ашиглалтад авсан он | Нэгж үнэ | Нийт үнэ | Үлдэх өртөг | Шилжүүлэн авах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 7 буудал /баруун тал/ | ш | 1 | 5/24/2024 | 8,175,691.65 | 8,175,691.65 | 8,175,691.65 | Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар |
| 2 | Чингэлтэйн 1-р буудал | ш | 1 | 5/24/2024 | 81,569,239.47 | 81,569,239.47 | 81,569,239.47 | |
| 3 | Чингэлтэйн 2-р буудал /Урд/ | ш | 1 | 5/24/2024 | 81,763,141.67 | 81,763,141.67 | 81,763,141.67 | |
| 4 | Чингэлтэйн 2-р буудал /хойд/ | ш | 1 | 5/24/2024 | 1,390,000,213.31 | 1,390,000,213.31 | 1,390,000,213.31 | |
| 5 | Чингэлтэйн 3-р буудал /Зүүн/ | ш | 1 | 5/24/2024 | 109,453,590.25 | 109,453,590.25 | 109,453,590.25 | |
| 6 | Чингэлтэйн 3-р буудал/Баруун/ | ш | 1 | 5/24/2024 | 150,219,419.42 | 150,219,419.42 | 150,219,419.42 | |
| 7 | Чингэлтэйн 4-р буудал /хойд/ | ш | 1 | 5/24/2024 | 77,854,015.01 | 77,854,015.01 | 77,854,015.01 | |
| 8 | Чингэлтэйн 4-р буудал /урд/ | ш | 1 | 5/24/2024 | 75,883,630.11 | 75,883,630.11 | 75,883,630.11 | |
| 9 | Чингэлтэйн 5-р буудал /урд/ | ш | 1 | 5/24/2024 | 75,073,966.15 | 75,073,966.15 | 75,073,966.15 | |
| 10 | Чингэлтэйн 5-р буудал /хойд/ | ш | 1 | 5/24/2024 | 76,776,164.95 | 76,776,164.95 | 76,776,164.95 | |
| 11 | Чингэлтэйн 6-р буудал /урд/ | ш | 1 | 5/24/2024 | 75,878,266.55 | 75,878,266.55 | 75,878,266.55 | |
| 12 | Чингэлтэйн 6-р буудал /хойд/ | ш | 1 | 5/24/2024 | 79,229,828.88 | 79,229,828.88 | 79,229,828.88 | |
| 13 | Чингэлтэйн хуучин эцэс /урд/ | ш | 1 | 5/24/2024 | 77,574,028.25 | 77,574,028.25 | 77,574,028.25 | |
| 14 | Чингэлтэйн хуучин эцэс /хойд/ | ш | 1 | 5/24/2024 | 78,518,754.23 | 78,518,754.23 | 78,518,754.23 | |
| 15 | Зүрх уулын 1-р буудал /урд/ | ш | 1 | 5/24/2024 | 78,861,599.30 | 78,861,599.30 | 78,861,599.30 | |
| 16 | Зүрх уулын 1-р буудал /хойд/ | ш | 1 | 5/24/2024 | 78,623,719.30 | 78,623,719.30 | 78,623,719.30 | |
| 17 | Зүрх уулын 2-р буудал /урд/ | ш | 1 | 5/24/2024 | 77,591,458.75 | 77,591,458.75 | 77,591,458.75 | |
| 18 | Зүрх уулын 2-р буудал /хойд/ | ш | 1 | 5/24/2024 | 74,106,069.67 | 74,106,069.67 | 74,106,069.67 | |
| 19 | Зүрх уул /Чингэлтэйн эцэс/ | ш | 1 | 5/24/2024 | 623,158,348.89 | 623,158,348.89 | 623,158,348.89 | |
| 20 | Замын аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжүүд | ш | 1 | 7/8/2024 | 586,661,581.80 | 586,661,581.80 | 586,661,581.80 | |
| 21 | Шилэн кабель | ш | 1 | 10/13/2023 | 271,889,433.60 | 271,889,433.60 | 271,889,433.60 | |
| **Нийт балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн** | | | | | | **4,228,862,161.20** | **4,228,862,161.20** | |